

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СЭТГҮҮЛИЙН ХАВТАСНЫ ДИЗАЙНЫ ОНЦЛОГ (1925-1936 ОН)

Д.Цэнд*

*СУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш

Түлхүүр үг: сэтгүүл, сэтгүүлийн хавтас, Монголын эмэгтэйчүүдийн сэтгүүлийн хавтас

Аливаа сэтгүүл хэвлэл мэдээллийн зах зээл дээр орших, эс орших нь түүний мэдээллийн багтаамжаас бус, харин гадаад өнгө үзэмж, цаас, хавтасны дизайнаас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс сэтгүүлийн хувьд өнгө үзэмж, зураг, хавтасны дизайн, шрифт зэрэг нь маш чухал юм.

Сониныг уншигчид гарчгийг нь уншаад худалдан авдаг бол сэтгүүлийг хавтас, зураг, гоёмсог харагдах байдал, цаасны чанар, дизайн зэрэг өнгө үзэмжний шийдлээс шалтгаалан худалдан авахаа шийддэг. Иймд сэтгүүлд хавтасны дизайн онцгой чухал үүрэгтэй. Сэтгүүл зүйн судлаач Б.Болд-Эрдэнэ “Сэтгүүлийн хавтас нь уншигчтай харилцахуйн хувьд хамгийн эхний төдийгүй, шийдвэрлэгч нөлөө бүхий орон зай билээ. Үүнд хавтасны зураг, дүрээр сэтгүүлийн агуулга, уншигчийн хүрээ, имиж, үнэ цэнэ төдийгүй, шинэ хуучин дугаар, өвөрмөц онцгой эсэх, басхүү дизайны мөн чанарыг хүртэл илэрхийлэх нь бий”¹ гэж тэмдэглэсэн байна.

Сэтгүүл нь уншигчийн сонирхлыг өдөөсөн, сонин, содон хийц, донж маягтай, гоёмсог зурагтай, өнгөний зохицол бүхий сайн хавтастай хэвлэг-

дэх нь тухайн сэтгүүлийн борлуулалтад ч нөлөөлөх нь.

Монголын сэтгүүлийн хөгжлийн эхэн үеийн төлөөлөл болох эмэгтэйчүүдийн сэтгүүл нь 1925 оноос эхлэн 2000-7000 хувь хэвлэгдэж байсан нь тухайн үедээ томоохон, нөлөө бүхий хэвлэл болохыг нотолж байна.

Монгол оронд ардын хувьсгал ялаад удаагүй, “Эмэгтэйчүүдийг богтлох явдлыг зогсоох Засгийн газрын шийдвэр 1925 онд гарч”² энэ үед нийгмийн нэгээхэн хэсэг болох эмэгтэйчүүдийг эрх чөлөө, хөгжил дэвшилд уриалсан, богтлох, дарлагдах, боолчлолоос чөлөөлөхөд сэтгүүлийн хавтас, зураг, агуулгыг зориулж байсан нь харагдаж байна.

1920-иод оны сүүлээр Монголын нийт хүн амын тоо 731.000 үүнээс эмэгтэйчүүд 337.571³ байсан. Энэ үед бичиг үсэгтэй хүн ховор, харанхуй, бүдүүлэг байсан эмэгтэйчүүдэд эрх чөлөөг олгох, бичиг үсэгт сургах, гэгээрүүлэх, соёлжуулах зайлшгүй шаардлага нь эмэгтэйчүүдийн сэтгүүл бий болох урьдач нөхцөл болжээ гэж үзэх үндэстэй юм. Нэгэнт сэтгүүл учраас мэдээллийг зурган мэдээллээр дамжуулан мэдээлэх нь чухал зүйл байсан дүр зураг сэтгүүлээс ажиглагдаж байна. Уншигчид сэтгүүлийг уншихаас илүүтэйгээр харж мэдээлэл авдаг. Иймээс

сэтгүүлийн хавтас ч нэмэлт мэдээлэл дамжуулж байдаг.



Зураг 1. “Бүсгүйчүүдийн санал” сэтгүүл. 1925 он.

1925 оны гуравдугаар сард “Бүсгүйчүүдийн санал” хэмээх Монголын эмэгтэйчүүдийн анхны сэтгүүл нь 13*17 см хэмжээтэй, 2000 ширхэгээр хэвлэгджээ. “Бүсгүйчүүдийн эрх чөлөө мандтугай” гэсэн лоозон бүхий туг барьсан монгол дээл өмсөж, бүсийг нарийхан бүсэлсэн, жанжин малгай, монгол гуталтай жавхаалаг эмэгтэйн араас мөн хувцас нь адил таван эмэгтэйг жагсаан зуржээ. Алсад тэнгэрийн дор мандан бадарч буй хүрээ, суурингийн наана эмэгтэйчүүд олноор харагдана. Энэ нь хувьсгалт монгол оронд эмэгтэйчүүд эрх чөлөөгөө олон мандан бадарч, нийгмийн амьдралд оролцон, сурч боловсорч буйг харуулсан төдийгүй ирээдүйн зам нь гэгээлэг байгааг бэлгэдэн зурсан байна. Баруун доод буланд нь тод хараар хүрээлсэн дөрвөлжин дотор “МАХН-ын Төв Хорооны дэргэдэх суртлын хэлтэс бүсгүйчүүдийн тасгаас сар бүр нэг удаа гаргана” хэмээн бичсэн байна. Тус сэтгүүлийн хавтасны талаар сэтгүүлч Ч.Батчулуун “Анхныхаа дугаарын хавтсанд “Бүсгүйчүүдийн эрх чөлөө мандтугай” гэсэн уриатай улаан туг барьсан эмэгтэйчүүдийн жагсаалыг харуулсан зураг нийтэлсэн нь санамсаргүй хэрэг биш бололтой. Тухайн үеийн намаас баримталсан гол бодлого нь эмэгтэйчүүдийн эрх чөлөөний

асуудал байсан учир ийнхүү уриалан дуудсан дайчин шинжтэй⁴ гэж тодорхойлсон байна. “Бүсгүйчүүдийн санал” сэтгүүл гурван дугаар хэвлэгдсний дараа “Эмэгтэйчүүдийн санал” нэрээр 1925 оны сүүлээс 1929 оныг хүртэл 12 дугаар хэвлэгджээ.



Зураг 2. “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүл. 1927 он.

Сэтгүүлийн хавтасны зураг нь тод хар хүрээн дотор нар мандаж буй баруун зүгрүү баруун гараараа заасан, таван хошуутай туг барьсан залуу эмэгтэй дөрвөн талтай малгай, монгол дээл өмсөж бүсээ нарийн жигд ороон, савхин гутал өмсчээ. Алсад мөн л хүрээ, суурин газрын зураг харагдана. “Ардын зориг агуу гайхамшиг, эмэгтэйчүүдийн эрх чөлөө бадартугай” гэсэн уриатай, хэмжээний хувьд өмнөх сэтгүүлтэй ижил, дөрвөлжин хар хүрээн дотор “Намын Төв хорооны эмэгтэйчүүдийн хэлтэс, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн салбараас сар тутам нэг удаа хэвлэн гаргана” гэж бичсэн байна. Өмнөх сэтгүүлийн нүүр зургаас ялгарах онцлог нь бүсгүйг ганцаар зурсан бөгөөд савхин гуталтай, барьсан туган дээр нь таван хошуу зурснаараа ялгаатай байна. Энэ нь Монголд үндэсний ажилчин анги буюу үндэсний үйлдвэр бий болж савхин гутал үйлдвэрлэх болсон, таван хошууг хувьсгал, ялалтын билэг тэмдэгээр хэрэглэж эхлэсэн үе юм. Ийнхүү нийгмийн дэвшлийг

сэтгүүлийн хавтсанд илэрхийлжээ. “Бүсгүйчүүдийн санал” нэрийг яагаад “Эмэгтэйчүүдийн санал” гэж нэрлэх болсон талаар ямар нэг баримт үлдээгүй байна. Гэвч бүсгүй гэдэг үг нь хуучин феодалын нийгмийн үг хэллэг, харин эмэгтэйчүүд гэдэг нь орчин үеийн шинэ нэр томъёог ашигласан байж болох юм. “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүдийн хавтас нь Монгол оронд мандсан шинэ нийгэм, журам, хувьсгалд эмэгтэйчүүдээ уриалан дуудсан, зарлан тунхагласан шинжтэй ажээ. “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүлийн дараа 1929 оны сүүлээр нэг, 1930 оны эхээр нэг дугаарыг “Эмэгтэйчүүдийн эрх” хэмээн нэрлэж хэмжээг багасган 12*14 хэмжээтэй хэвлэжээ. Сэтгүүлийн нэрийг “Эмэгтэйчүүдийн эрх” хэмээн өөрчлөх болсон шалтгаан нь Монгол улс 1924 оны 11-р сарын 26-ний өдөр батласан БНМАУ-ын. Анхдугаар Үндсэн хуулинд “Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүл”⁵ гэж зааснаар хуулиар хамгаалагдсан эрх чөлөөгөө илэрхийлэх, мөн 1925 онд эмэгтэйчүүдийг богтлох явдлыг хориглосон засгийн газрын тогтоол гарсан нь эмэгтэйчүүдийг эрх чөлөөтэй болсныг зарласан шийдвэр зэрэг нь сэтгүүлийн нэр өөрчлөгдөх шалтгаан болсон байх үндэстэй юм.



Зураг 3. “Эмэгтэйчүүдийн эрх” сэтгүүл. 1930 он.

“Эмэгтэйчүүдийн эрх” сэтгүүлийн хавтсыг хар зураасаар хүрээлж гурван хэсэгт хуваасан байна. Эхний хэсэгт таван хошууны зурагтай “Эмэгтэйчүүдийн эрх” гэж бичсэн бол дараагийн хэсэгт улаан гэрийн гадаа ном заалгаж буй эмэгтэйчүүд, гуравдахь хэсэгт малынхаа дэргэд хүүхдээ хөтлөөд зогсож буй эмэгтэйг, гадуураа цацрагтай таван хошуу руу зааж, уриалж, буй цүнх барьсан орчин цагийн эмэгтэйн дүр зургийг дүрслэн өгүүлсэн байна. “Бүх дэлхийн үгээгүй нар нэгдэгтүн, эмэгтэйчүүдийн эрх чөлөө бадартугай” гэсэн уриатайгаар намын төв хорооны эмэгтэйчүүдийн хэлтсээс хэвлэжээ. Маркс, Энгельс нарын “Орон бүхний пролетари нэр нэгдэгтүн” гэсэн коммунист тунхаглалын уриаг Монголд 1920-иод оноос “Монголын үнэн” сонин анх хэрэглэсэн байдаг. Энэ уриаг 1990 оныг хүртэл аливаа хэвлэл бүгд хэрэглэж байв. Эмэгтэйчүүдийн сэтгүүл нь 1930-аад оноос ийнхүү “Бүх дэлхийн үгээгүй нар нэгдэгтүн” гэсэн үг өөр ч агуулга нэг хэрэглэж байжээ. 1929, 1930-аад онд хувьсгалын эхний жилүүдийг бодоход эмэгтэйчүүд хуучны дадал, дарлал, боолчлолоос ангижирсан, бичиг үсэгтэй эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна. “1923 оны үед улсын байгууллагад зөвхөн долоон эмэгтэй ажиллаж байсан бол 1928 онд улсын байгууллагад 70 эмэгтэй ажиллаж бичиг үсэгтэй эмэгтэйчүүд 200-300 шахам болжээ⁶. Бичиг үсэг сурсан эмэгтэйчүүд нь Монгол орны өргөн уудам нутаг дэвсгэрийн өнцөг булан бүрт очиж хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн соёл боловсролын төв болсон “Улаан гэр”-ийг байгуулж бичиг үсэг сургаж, жүжиг ший тоглож, нэгтгэх, хамтын хүчийн давуу талыг ухуулж байсан байдаг. 1929 оны долоодугаар сард Намын Төв хороо-

ноос орон нутагт эмэгтэйчүүдийн “улаан гэр” байгуулах тогтоол⁷ гаргаж, улаан гэрийн эрхлэгчийг курс сургуулиар бэлтгэж байжээ. Ийнхүү сэтгүүл нь хавтсаа тухайн нийгэм, цаг үеийн асуудалд хувьсгалч байр сууринаас хандан өөрчилж байсан байна. “Эмэгтэйчүүдийн эрх” сэтгүүлийн дараа 1929 оны сүүл үеэс 1932 оныг хүртэл “Ажилчин эмэгтэй” нэрээр 13 дугаар 13*17 см, 14*25 см хэмжээтэй 3000-7000 ширхэгээр хэвлэгджээ. Монгол оронд жижиг техник бүхий гар ажиллагаатай аж үйлдвэрийн байгууллага, цөөн боловч үндэсний гар урчууд, улирлын ба байнгын хөлсний ажилчид зэрэг Монголын ажилчид, үндэсний ажилчин анги үүсэх болсон энэ үеэс сэтгүүл нэрээ өөрчлөн “Ажилчин эмэгтэй” нэртэй болжээ. 1930-аад он бол Монголд ажилчин, малчин, сэхээтний анги давхарга бий болж тэдний эгнээнд эмэгтэйчүүдийг олноор оруулах, сурталчлах явдал чухал байсан учир сэтгүүлийг ийнхүү нэрлэжээ.



Зураг 4. “Ажилчин эмэгтэй” сэтгүүл .1930 он.

Сэтгүүлийн хавтсыг хар зураасаар гурав хувааж эхний хэсэгт таван хошуу, хоёрдахь хэсэгт сэтгүүлийн нэр, гурав дахь хэсэгт “Энэхүү сэтгүүлийг эмэгтэйчүүдийн хэлтэсээс сар тутам нэг удаа хэвлэн нийтэлнэ” гэж бичсэн ба эргэн тойрон бат бэх хязгааргүйн бэлгэдэл монгол хээ угалзаар хүрээл-

сэн байна. Таван хошуу нь тухайн нийгэмд хувьсгалын ялалт, эрч хүч, эрэмгий зоригын илэрхийлэл болгон хэрэглэж байсан учир эмэгтэйчүүдийг уриалан дуудаж сэтгүүлдээ ийнхүү хэрэглэж байжээ. “Ажилчин эмэгтэй” сэтгүүл “Ажилч эмэгтэй” нэрээр нэг дугаар гарсан байдаг. Энэ нь ажилчин гэдэг нь мэргэшил, ажилч гэдэг нь гэр орон, амьдрал ахуйдаа ажилч байх чанарыг харуулж нэрлэсэн ажээ.



Зураг 5. “Ажилч эмэгтэй” сэтгүүл.1930 он.

Сэтгүүлийн нүүрэнд таван хошууны баруун, зүүн талд нэрийг бичиж, доор нь үүдэндээ хаяг хадсан гэрийн гадаа хувин сав, сүүний цөцгийн машин, майхны гадаа өндөр ширээ, наана нь савхин гуталтай, зөвлөлтийн хувьсгалт эмэгтэйчүүдийн үсний тайралтын загвараар үсээ тайрсан тайрмал үстэй эмэгтэй гартаа ном барьсан, богино ханцуйтай дан дээл өмссөн, хөлний гишгэлтээс харахад орчин цагийн нэлээд дэгжин эмэгтэй хүүхэдтэй ярилцаж байгаа зурагтай байна. Энэ үеэс эмэгтэйчүүдийн сэтгүүл хүүхдийн хүмүүжил, боловсролд анхаарч хүүхдээ орчин үеийн боловсон газар төрүүлэх, хүүхэд саатуулах газарт өгөхийг уриалсан сурталчилсан зургууд ихээр нийтлэсэн байдаг. Доор нь “Энэхүү сэтгүүлийг эмэгтэйчүүдийн хэлтэсээс сар тутам нэг удаа хэвлэн нийтэлнэ” гэж бичжээ.

Эмэгтэйчүүдийн сэтгүүл эхэн үедээ эмэгтэйчүүдийг эрх чөлөөгөө олоход нь туслах байсан бол 1930-аад оноос соёлжуулах, боловсруулах ажил эрчимжиж, европын соёл нэвтэрч хувин сав, гар ажиллагаатай техникүүд нэвтэрч ахуйд өөрчлөлт орж ирсэн тул сэтгүүл мөн нийгмийн өөрчлөлтөд зориулан хавтсаа өөрчилсөн байна. 13*17 хэмжээтэй байсан бол 14*25 хэмжээтэй болсон, хуудасны тоо нэмэгдсэн, зурмал зураг хэвлэгдэх болсон зэрэг давуу талууд ажиглагдаж байна. “Ажилчин эмэгтэй” сэтгүүл нь 1930-аад оны дугааруудаас эхлэн зурмал зураг нийтлэх болсон нь бичиг үсэггүй эмэгтэйчүүд, хүүхэд зургийг харж мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн нь сэтгүүлийн давуу тал юм.




Зураг 6. “Ажилчин эмэгтэй” сэтгүүл. 1932 он.

Эмэгтэйчүүдийн сэтгүүл нь 1932 оны зарим дугаарын хавтсыг өнгөтөөр хэвлэсэн нь өнгө үзэмж төдийгүй, сэтгүүлийн дизайнд гарсан ахиц дэвшил байлаа. Хүний таван мэдрэхүйн нэг нь харах байдаг. Харах мэдрэхүй нь хамгийн түрүүнд өнгөний зохицолоор мэдээллийг хүлээн авна. Сэтгүүлийн нүүр өнгөт болсон нь мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах, уншигчийн хүрээг тэлэх, сонирхлыг татах, техник технологийн дэвшлийг харуулах гэх мэт олон сайн талтай юм.

Баруун гартаа урт улаан иштэй улаан туг барьсан, улаан бүч хүзүүндээ зүүсэн, цэнхэр дээлтэй, ногоон бүстэй, шовгор ногоон малгайтай, трапец өмдтэй, европ гуталтай залуухан бүсгүй зүүн гараараа нарны алтан цацраг тийш зааж байна. Бүсгүйн наана газар дэлхийг бэлгэдэн ногоон өнгөн дээр Зөвлөлтийн алх хадуурыг шараар зуржээ. Энэ үед зөвлөлтийн нөлөө ихээр орж ирж байсан учир алх хадуурыг дүрсэлсэн байна. Сэтгүүлийн нэрийг улаан өнгөөр бичсэн бөгөөд улаан өнгө голлосон нь тэмцэл ялалтын бэлгэдсэн бол цэнхэр өнгөөр тэнгэрийг, ногоон өнгөөр газар дэлхийг бэлгэдсэн байна. Сэтгүүлийн зурагт улаан, цэнхэр, ногоон, шар зэрэг хөнгөн суурь өнгийг гол болгосон бөгөөд өнгөний зохицлыг зөв тогтоон ашигласан байна.

“Ажилчин эмэгтэй” сэтгүүл 13 дугаар хэвлэгдэхдээ хавтасаа гурван удаа хэмжээгээ хоёр удаа өөрчилжээ. 1932 онд эмэгтэйчүүдийн сэтгүүл нь “Малчин эмэгтэй” нэрээр 12*25 см хэмжээтэй 3000 ширхэг 25 хуудастай зурмал зурагтай эмэгтэйчүүдийн хэлтсээс эрхлэн нэг дугаар гарсан байна. Энэ үед эмэгтэйчүүдийн дийлэнх хувийг малчин эмэгтэйчүүд эзэлж байсан учир ийнхүү нэрээ өөрчилжээ.



Зураг 7. “Малчин эмэгтэй” сэтгүүл. 1932 он.

Сэтгүүлийн хавтсанд том таван хошууны голд нь гэр зураад хошуу тус

бүрт шинэ нийгмийн үйл явцыг зургаар үзүүлж тайлбарыг жижиг үсгээр бичжээ. Тухайлбал: Эхний хошуу дотор бичиг үсэг сурмой гээд самбарын өмнө хүүхдүүдээ суулгаад хичээл зааж буй эмэгтэйн зураг байхад дараагийн хошуу нь эх нялхсыг хамгаалах явдал, бүсгүйчүүдийн улаан гэр, сүү боловсруулах ажил, хүүхдийн цэцэрлэг буюу хүүхэд саатуулах газрын тухай зэрэг 1930-аад оны эмэгтэйчүүдийн дунд өрнөж буй соёл, хүмүүжил, боловсролын ажлыг харуулсан байна. Мөн билэгдэл талаасаа ч хөмөрсөн тогоон доторх шиг байсан монгол эмэгтэйчүүд шинэ цагийн соёл, шинжлэх ухаанд боловсрон дэвжин дээшилж, хөгжин дэвжиж байгааг харуулжээ. Энэ үед бүсгүйчүүдийг бичиг үсэгт сургахаас гадна, эрүүлжүүлж, эх хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, эмэгтэйчүүдийг улс орны бүтээн байгуулалтад уриалан дуудах, ажилчин ангийн эгнээг өргөтгөх жилүүд байсан учир хавтасны зургийг танин мэдүүлсэн, уриалан дуудсан байхаар үзүүлжээ. Малчин эмэгтэй сэтгүүлийн дараа 1933-1935 оны хугацаанд эмэгтэйчүүдийн сэтгүүл хэвлэгдээгүй бөгөөд малчдыг хамтралжуулах бодлого, тайж, лам нар болон баячуулын хөрөнгө хураахыг эсэргүүцсэн монголчуудын зэвсэгт бослого, 1930-аад оны их хэлмэгдүүлэлт зэрэг нөлөөлж сэтгүүл хэвлэгдээгүй байна.

1936 онд “Эмэгтэйчүүдийн сэтгүүл” нэрээр нэг дугаар хэвлэгдсэн байна. Эмэгтэйчүүдийн сэтгүүлийн нэр олон удаа өөрчлөгдсөн нь тухайн нийгмийн хөгжил, эмэгтэйчүүдэд тулгарч байсан асуудлуудтай холбон нэрээ өөрчилж байжээ.

Дүгнэлт. Сэтгүүл нь нэрээ өөрчлөх бүрт нүүр зураг, уриа, эрхлэн гаргасан газар,

хэмжээ, хуудасны тоо, үнэ зэрэг нь өөрчлөгдөж байжээ. 1925-1936 оны хооронд нэрийг долоо, уриаг гурав, хавтасны зураг ес, хэмжээг гурван удаа тус тус өөрчилсөн байна. Сэтгүүл хар цагаанаар хэвлэгдэх бүрт нүүр зургийг цагаан дэвсгэр дээр хараар зурж, бичиж байсан нь тод, уншихад хялбар хүний нүдэнд ядаргаагүй байсан төдийгүй хадгалалтын нөхцөлд дүрс, бичиг нь бүдгэрээгүй байгаа нь сэтгүүлийн бас нэг онцлог давуу тал гэж хэлж болохоор байгаа юм. Цагаан дэвсгэр дээр хараар бичихэд бусад өнгөнөөс 42% илүү хурдан уншигддаг болохыг 1920-иод онд Старч хэмээх эрдэмтэн нотолжээ.

Сэтгүүлийн нүүрийг өнгөтөөр хэвлэх болсон нь нийгмийн хөгжлийн шаардлага, техник технологийн дэвшилийн үр дүн, нөлөө байсан. Сэтгүүлийн нүүрэн дээр сард нэг, хоёр удаа гаргана хэмээн бичсэн боловч хугацаандаа хэвлэгдэж чаддаггүй байсныг 11 жилийн дотор 28 дугаар хэвлэгдсэн байгаагаас харж болно. Энэ нь тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн байдал, хэвлэх үйлдвэрийн хүчин чадал, цаас, сэтгүүлд материал бичих боловсон хүчний дутагдал зэргээс шалтгаалсан байх магадлалтай.

Монголын эмэгтэйчүүдийн анхны сэтгүүлүүдийн хавтас нь тухайн нийгмийн бүсгүйчүүдийг эрх чөлөөгөө олоход нь туслах, гэгээрүүлэх, соёлжуулах, бичиг үсэгт сургах шинэ нийгмийн үзэл санааг уриалан дуудаж, улмаар оюун санааг өөрчилсөн, дайчин дүр дүрслэл бүхий хавтастай хэвлэгдэж байжээ.

Ишлэл

- ¹ Болд-Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ. х.106.
- ² Засгийн газрын тогтоол, шийдвэрийн эмхэтгэл

- ³ “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүл. 1928. №5
- ⁴ Батчулуун Ч. Монголын эмэгтэйчүүдийн хэвлэлийн тойм. УБ. 1982
- ⁵ БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хууль. 1924 он
- ⁶ “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүл 1928. №6
- ⁷ МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ. 1929. МАХН-ын төв архив.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. “Ажилчин эмэгтэй” сэтгүүл, 1929-1931 оны дугаарууд
2. “Ажилч эмэгтэй” сэтгүүл, 1930 он
3. Батчулуун Ч. Монголын эмэгтэйчүүдийн хэвлэлийн тойм, 1982. УБ.
4. Болд-Эрдэнэ Б. Сонины дизайн. 2004. УБ.
5. “Бүсгүйчүүдийн санал хэмээх сэтгүүл” 1925 оны дугаарууд
6. Дэлэг Г. Монголын хэвлэл, 2014. УБ.
7. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. 2005. УБ.
8. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм, 1,2 боть. 2001. УБ.

9. Содномдаржаа Т. Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх. 1965. УБ.
10. “Эмэгтэйчүүдийн санал хэмээх сэтгүүл” 1925-1929 оны дугаар.
11. “Эмэгтэйчүүдийн эрх” сэтгүүл, 1929 оны дугаар.

Summary

In this paper, cover design features of “Mongolian women’ magazine” which published between 1925-1936s were analyzed. That time, “Mongolian women’ magazine” changed its’ name to seven, its’ slogan to three, its’ folder design to nine, and its’ size three times. The price also increased to 10, 15, 18 and 25 mungu. Color printing on magazine covers began in 1932 as a result of technological and social development. Author tries to analyze cover design features through 10 years with the social changes.